

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН /2012-2016 он / ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

ЗОРИЛТ 84. Монгол Улс руу чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг хоёр дахин нэмэгдүүлэх

Арга хэмжээ 84.1: Агаарын харилцааны асуудлаар Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах замаар олон улсын нислэгийн чиглэл, давтамжийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ./2013-2016 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Чиглэл 5-аас доошгүй, нислэгийн давтамж 2 дахин нэмэгдсэн байна.

Хэрэгжилт: Агаарын харилцааны хэлэлцээрийг 1 улстай шинээр байгуулав:

Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т 2013 оны 9 дугаар сарын 05-ны өдөр гарын үсэг зурсан бөгөөд Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ни й өдрийн 179 дүгээр тогтоолоор уг хэлэлцээрийг баталсан.

Агаарын харилцааны хэлэлцээрийг 1 улстай шинэчлэн байгуулсан:

1998 онд байгуулсан" Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т 2015 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчилж гарын үсэг зурсан бөгөөд Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 276 дугаар тогтоолоор уг хэлэлцээрийг баталсан.

21 улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулав: Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Засгийн газар хоорондын 2013 оны 10 дугаар сарын 10-11-нд болсон Агаарын харилцааны тухай хэлэлцээрээр нислэгийн давтамжийг 11 болгон нэмэгдүүлж, гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран эзэмших тухай Харилцан ойлголцлолын санамж бичиг байгуулсан.

2. 2013 оны 11 дүгээр сарын 20-21-нд болсон Япон Улсын Иргэний нисэхийн удирдах газар, Монгол Улсын Иргэний нисэхийн удирдах газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн үеэр нислэгийн давтамжийг 7, багтаамжийг 10.5 болгож, нислэгийн цэгүүдийг нэмэгдүүлж, гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран эзэмших зохицуулалт тохирч, маршрутын хуваарь болон хоёр улс хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн зарим хэсгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан

3. Австри, ИБУИНВУ, Сингапур, Швейцарь Улстай аялалын дугаар хуваан эзэмших зохицуулалтыг тохирч, 2013 оны 12 дугаар сарын 12-нд Харилцан ойлголцлолын санамж бичиг байгуулсан.

4.БНКазУ-тай 2014 оны 4 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд хэлэлцээ хийж, нислэгийн цэгийг 2-оор нэмэгдүүлж, хоёр орны хооронд гүйцэтгэх нислэгийн багтаамжийг 7 хоногт 800 суудал байхаар тохирч Харилцан ойлголцлолын санамж бичиг 2014 оны 5 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан.

5.БНСУ-тай 2014 оны 4 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд хэлэлцээ хийж, Бусан нислэгийн цэгт 2016 оны зуны улирлаас нислэгийг эхлүүлэхээр, Улаанбаатар-Сөүл нислэгийн шугаманд "нэг чиглэл-нэг тээвэрлэгч" зарчмыг 2020 он хүртэл баримтлахаар, хоёр орны хооронд визийг чөлөөлөх нөхцөлд энэ зарчмыг эргэн харахаар тус тус тохирч, тохиролцсон асуудлаар Харилцан ойлголцлолын санамж бичиг 2014 оны 4 дүгээр сарын 11-нд байгуулсан.

6.ХБНГУ-тай 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөр уулзалт, хэлэлцээ хийж, аялалын дугаар хуваан ашиглах зохицуулалтыг тохирч, тохиролцлын бичиг байгуулсан.

7. БНТуркУ-тай Агаарын харилцааны асуудлаар 2014 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд хэлэлцээ хийж тэмдэглэл гаргасан.

8. ОХУ-ын Новосибирск хотод энэ оны 05 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Транспорт Сибирь чуулга уулзалтын үеэр ОХУ-ын нутаг дэвсгэр дэх нисэн очих цэг Барнаулыг Екатеринбург цэгээр сольж, харилцан тохирч Харилцан ойлголцлолын санамж бичиг 2015 оны 5 дугаар сарын 23-нд байгуулсан. Түүнчлэн Сочи, Владивосток, Калининград хотууд руу ИАТА-гийн 3 улирлын турш нислэгийн 5 дугаар эрх эдлэн захиалгат, тогтмол нислэг үйлдэх эрх авсан.

9.Монгол Улсын Засгийн газар болон Мьянмар Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн бичвэрийг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр тохирон үзэглэсэн ба хоёр талаас томилогдсон агаарын тээврийн байгууллагууд 7 хоногт 3 хүртэлх давтамжаар 500 суудлын багтаамжтай нислэг үйлдэхээр тохирч Санамж бичиг байгуулсан.

10.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн бичвэрийг энэ оны 10 дугаар сарын 19-ны өдөр тохирон үзэглэж, Харилцан ойлголцлын санамж бичиг 2015 оны 9 дүгээр сарын 09-нд байгуулсан.

11.Монгол Улсын Засгийн газар болон Мальта Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн бичвэрийг 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр тохирч үзэглэсэн. Мөн 2 талаас томилогдсон агаарын тээврийн байгууллагууд 7 хоногт 3 хүртэлх давтамжаар 500 суудлын багтаамжтай нислэг үйлдэхээр тохирч Санамж бичиг 2015 оны 9 дүгээр сарын 22-нд байгуулсан.

12.Монгол Улсын Засгийн газар болон Люксембургийн Их Вант Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн бичвэрийг энэ оны 10 дугаар сарын 20-ны өдөр тохирч үзэглэсэн. Уулзалт, хэлэлцээгээр зорчигч тээврийн үйлчилгээ 7 хоногт 3 хүртэлх давтамжаар 500 суудлын багтаамжтай байх, дан ачаа тээврийн нислэг 7 хоногт 2 байхаар тохирсон ба Люксембургийн талаас Cargolux Airlines International, Монголын талаас “МИАТ” ХК-ийг томилж Санамж бичиг 2015 оны 9 дүгээр сарын 20-нд байгуулсан.

13.БНСУ-ын нисэхийн удирдах байгууллагын төлөөлөгчидтэй 10 дугаар сарын 21-ний өдөр уулзаж, 2016 оны зуны улирлаас хоёр талын томилогдсон агаарын тээврийн байгууллага Бусан-Улаанбаатар чиглэлд B737, A320, A321 маягийн агаарын хөлгөөр 7 хоногт 2 удаагийн давтамжаар 162 суудлын хязгаарлалттай нислэг үйлдэхээр тохирч Санамж бичиг 2015 оны 10 дугаар сарын 21-нд байгуулсан.

14.Австралийн талтай аяллын дугаар хамтран эзэмших зохицуулалтыг тохирч, 2015 оны 03 дугаар сарын 20-нд санамж бичиг байгуулсан.

15. Монгол Улсын Зам, тээврийн сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2013 оны 9 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд хийсэн айлчлалын үеэр Улаанбаатар-Бээжин-Ханой, Улаанбаатар-Бээжин-Сингапур, Улаанбаатар-Шанхай-Бангкок чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрх авч, Харилцан ойлголцлолын санамж бичиг 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан.

16.Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох талаар дипломат шугамаар харилцах, Монголын талын авиакомпаниуд нислэг үйлдэж эхлэх үед Беларусийн нисэх онгоцны буудлуудыг техникийн буулт болон түлш цэнэглэх зорилгоор ашиглах боломжийг шийдвэрлүүлэх, Монгол Улсад онгоцны түлш нийлүүлэх саналыг Беларусийн тал дэмжин, Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлолын санамж бичиг 2014 оны 3 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан.

17. Монгол Улс, Швейцарийн Холбооны Улсын төлөөлөгчид уулзалт, хэлэлцээ хийж, хоёр тал Агаарын харилцааны хэлэлцээрт өөрчлөлт оруулах талаар 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Протокол байгуулж, нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодын журмаа гүйцээн, ноот бичиг солилцон баталгаажуулахаар тохирсон.

Шинээр нээсэн нислэгийн чиглэл:

- 2013 оны 6 дугаар сараас шинээр Тайланд, Эрээний чиглэлд чартерын нислэг үйлдэж эхэлсэн.
- “МИАТ” ТӨХК энэ оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс 2014 оны 09 дүгээр сарын 21-ний хооронд Улаанбаатар-Франкфурт-Улаанбаатарын чиглэлд нислэг үйлдсэн.
- “Хүннү Эйр” ХХК 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 2014 оны 08 дугаар сарын 29–ний хооронд Улаанбаатар-Парис-Улаанбаатарын чиглэлд улирлын чанартай нислэг үйлдсэн.
- “МИАТ” ХК 2014 оны 09 дүгээр сарын 24-нөөс эхлэн Улаанбаатар-Бээжин-Сингапур-Улаанбаатарын чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн.
- “Хүннү Эйр” ХХК 2014 оны 09 дүгээр сараас Хайлаар, Манжуурын чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн.
- ОХУ-ын “Ир Аеро” ООУ Улан-Удэ-Улаанбаатар-Улан-Удэ чиглэлд 2015 оны 10 дугаар сарын 09-нөөс нислэг үйлдэж эхэлсэн.

Олон улсын 16 чиглэлд тогтмол нислэг үйлдэж байсан бол 2015 оны жилийн эцсийн байдлаар 15 чиглэлд / Бээжин, Бээжин-Сингапур 2015 оны 3 дугаар сарыг дуустал ниссэн, Сөүл, Токио, Хонгконг, Москва, Берлин, Франкфурт 2014 оны 6-9 саруудад ниссэн, Хөх хот, Эрхүү Хайлаар, Манжуур, Бишкек, Станбул, Улан-Удэ 2015 оны 10 дугаар сараас нислэг үйлдэж байна./

	2012 оны нислэгийн давтамж <i>/7 хоногт/</i>	2015 оны нислэгийн давтамж <i>/7 хоногт/</i>
1.	Бээжин МИАТ ТӨХК 14 Air China 12	Бээжин МИАТ ТӨХК 10 Air China 7
2.	Сөүл МИАТ ТӨХК 9 Korean air 7	Сөүл МИАТ ТӨХК 7 Korean air 11
3.	Хонгконг 4	Хонгконг 5
4.	Токио 4	Токио 7
5.	Осака 2	Москва МИАТ ТӨХК 2
6.	Москва МИАТ ТӨХ 2	Aeroflot 7
7.	Aeroflot 7	Берлин 2
8.	Берлин 3	Франкфурт /2015 оны 6-9 саруудад ниссэн. / 2
9.	Хөх хот 7	Хөх хот 5
10.	Эрхүү 2	Эрхүү 3
11.	Улаан Үүд 3	Хайлаар 2
12.	Хайлаар 4	Манжуур 3
13.	Бишкек- Станбул 3	Бишкек- Станбул 3
		Улан- Удэ 2
		Бээжин-Сингапур /3 дугаар сарыг дуустал ниссэн./

Арга хэмжээ 84.2: Агаарын хөлгийн парк шинэчлэлтийн төслийг хэрэгжүүлж, Ази, Европын чиглэлийн нислэгийн сүлжээг өргөжүүлнэ./2013-2016 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Өөрийн өмчлөлийн агаарын 3 хөлөгтэй болсон байна.

Хэрэгжилт: Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, агаарын хөлгийн паркийг шинэчлэх зорилгоор АНУ-ын Боинг компаниас “Боинг 767-300ER” загварын агаарын хөлөг нэг ширхэг, “Боинг 737-800NG” загварын агаарын хөлөг хоёр ширхэгийг худалдан авах гэрээг 2011 оны 06 дугаар сард Монгол Улсын ерөнхийлөгч АНУ-д хийсэн айлчлалын үеэр байгуулсан. Уг гэрээний дагуу эхний ээлжинд “Боинг 767-300ER” агаарын хөлгийг 2013 оны 05 дугаар сард худалдан авсан бол дараагийн ээлжинд хоёр ширхэг “Боинг 737-800NG” агаарын хөлгүүдийг 2016 оны нэгдүгээр улиралд худалдан авах төлөвлөгөөтэй байсан. Агаарын хөлөг худалдан гэрээний дагуу АНУ-ын “Боинг” компаниас эхний ээлжинд нэг ширхэг “Боинг 767-300ER” агаарын хөлгийг 2013 оны 05 дугаар сарын 15-нд хүлээн аваад байна. Агаарын хөлөг худалдан авах гэрээний дагуу 2016 онд хүлээн авах байсан хоёр ширхэг “Боинг 737-800NG” агаарын хөлгийн урьдчилгаа төлбөрт” 2014, 2015 онд төлөгдөх шаардлагатай байсан урьдчилгаа төлбөр болон 2016 оны эхний улиралд төлөгдөх шаардлагатай байсан үлдэгдэл төлбөрийг тус тус төлөх боломжгүй болсон талаар АНУ-ын “Боинг” компанид удаа дараа мэдэгдсэний дагуу талууд харилцан ашигтай шийдлийг олохоор хамтран ажиллаж байна.

Арга хэмжээ 84.3: Европын холбооны улсын нутаг дэвсгэрт агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрх авах зохицуулалтыг түлхүү бүрдүүлж, шинээр Сингапур, БНЭУ руу хуваарьт нислэг гүйцэтгэнэ./2013-2016 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Сингапур, Энэтхэг Улс руу хуваарьт нислэг гүйцэтгэдэг болсон байна.

Хэрэгжилт: 1998 онд байгуулсан” Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т 2015 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчилж гарын үсэг зурсан бөгөөд Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 276 дугаар тогтоолоор уг хэлэлцээрийг баталсан. Сингапурын талтай 2013 оны 12 дугаар сарын 12-нд хийсэн агаарын харилцааны хэлэлцээгээр нислэгийн давтамжийг долоо хоногийн 2 байгааг 3 болгон нэмэгдүүлж, дундын 2 цэгийг тогтоож, агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрхтэй байхаар тохирч Санамж бичиг байгуулсан. 2013 оны 9 дүгээр сарын 26-нд БНХАУ-ын талтай хийсэн хоёр талын уулзалтаар Бээжин-Сингапурын чиглэлд Монголын талаас нислэг үйлдэх 5 дугаар эрхийг авч, агаарын тээврийн 5 дугаар эрхтэй болон шууд нислэг гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. БНЭУ, Сингапур Улс руу нислэг үйлдэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

“МИАТ” ТӨХК нь 2014 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс Улаанбаатар-Бээжин-Сингапур чиглэлд долоо хоногт хоёр удаагийн хуваарьт нислэг гүйцэтгэж эхэлсэн боловч суудал ашиглалт УБ-Бээжин-УБ секторт 83.8 хувь, Бээжин-Сингапур-Бээжин секторт 47.0 хувьтай, үйл ажиллагааны зардлаар тооцоход 5,97 тэрбум төгрөгийн алдагдал байсан. “МИАТ” ТӨХК нь одоогийн байдлаар санхүүгийн хүндрэлтэй, энэхүү чиглэлд үргэлжлүүлэн ниссэн тохиолдолд алдагдал даах чадамжгүй байсан тул Төрийн өмчийн хорооны 2015 оны 1 дүгээр сарын 29-ын өдрийн) хуралдаанаар Сингапурын чиглэлийн нислэгийг зогсоох шийдвэр гаргасан. Улмаар 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс нислэгийн зогсоосон.

ЗОРИЛТ 85: Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулах

Арга хэмжээ: Дадал, Хатгал, Хархорины нисэх буудлын үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сэргээж нислэг үйлдэх боломжийг бүрдүүлнэ./2013 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Хэрэгжилт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хатгал нисэх буудлын хөөрч буух шороон зурваст 2012 онд 430.9 сая, 2013 онд 96 сая төгрөгийн, Хархорин нисэх буудлын зорчигч

үйлчилгээний барилга болон хөөрч буух шороон зурваст 2011 онд 74.9 сая төгрөгийн их засварын ажлыг тус тус гүйцэтгэсэн. 2014 онд Дадал нисэх буудалд нислэг үйлдэх бэлтгэлийг хангах зорилгоор хөөрч буух зурвасын даацыг тодорхойлж, нислэгийн талбайн хэмжилтийг хийн, ил, харааны тэмдэгийг байрлуулсан. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тус нисэх буудлууд нислэг хүлээн авах бүрэн боломжтой болсон. Дадал, Хатгал, Хархорины нисэх буудлууд нь ИНД-139, ИНД-140 дүгээр дүрмүүдээр гэрчилгээжсэн бөгөөд цагт 50 зорчигч хүлээн авах хүчин чадалтай ба багаас дунд оврын агаарын хөлөг хүлээн авах шаардлагыг бүрэн хангаад байна. Манай улсын автозамын сүлжээ өргөжин тэлэхийн хирээр автозамын тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан, агаарын хөлгийн шатахууны өндөр үнэ, валютын ханшны байнгын өсөлтөөс шалтгаалж агаарын тээврийн үйлчилгээний үнэ тариф буурахгүй байгаа нь агаарын тээвэр автозамын тээвэртэй өрсөлдөхөд хүндрэлтэй болсоор байна. Үнийн хувьд авто замын тээвэр нь агаарын тээврээс 7-9 дахин хямд байгаа тул зах зээлгүй болсон. Орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагааг сэргээх ажлыг “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д тусгасан “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн хүрээнд шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна.

ЗОРИЛТ 114: Далайд гарцгүй орны хувьд агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин хөгжүүлэх

Арга хэмжээ 114.1 : Иргэний нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулна./2012 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Бодлогыг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

Хэрэгжилт: Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 18 дугаар тогтоолоор “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг баталсан.

ЗОРИЛТ 115: Хөшигийн хөндийд шинээр барих олон улсын нисэх онгоцны буудлыг олон улсын зорчигч болон ачаа тээврийн өрсөлдөх чадвар бүхий төв болгох
Арга хэмжээ 1: Шинэ нисэх буудлын барилгын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ./2013-2016 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна.

Хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ 2013 оны 3 дугаар сард албан ёсны айлчлал хийх үеэр шинэ нисэх буудлын барилгын ажлыг яаралтай эхлүүлэн 2016 онд ашиглалтад оруулах талаар ярилцаж, шаардагдаж буй нэмэлт хөрөнгийг хөнгөлөлттэй нөхцлөөр нэмэлт зээл олгонх талаар зарчмын тохиролцоонд хүрсэн. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэмэлт зээлийн хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөх чиглэл өгсний дагуу 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулан дэмжүүлж, зөвшөөрсөн. Төслийн барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Мицубиши, Чиёда” компаниудын түншлэлийг шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээг 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, гэрээг ЖАЙКА байгууллагаар хянуулан, 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдөр гэрээг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг тус байгууллагаас ирүүлсэн. Үүний дагуу нисэх буудлын барилгын ажлыг 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлүүлсэн. 2015 оны жилийн эцсийн байдлаар барилгын ажил 70.7%-тай, төлөвлөснөөс 4.4%-иар хэрэгжиж байна.

Зорилт 116: Агаарын тээврийн салбарыг өмчийн олон хэлбэртэй, чөлөөт өрсөлдөөнтэй болгох бодлогыг 2016 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлэх/2013-2016 он/

Арга хэмжээ116.1: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Чингис хаан” олон улсын нисэх буудал, орон нутгийн зарим нисэх буудлуудын менежментийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлнэ.

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: *Менежментийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж эхэлсэн байна.*

Хэрэгжилт: Төрийн өмчийн хорооны 2012 оны 422 дугаар тогтоолоор “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зарчмаар ажиллуулах асуудлыг Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран боловсруулж шийдвэрлүүлэх чиглэл өгсөн. Энэ ажлын хүрээнд “Чингис хаан” олон улсын буудлын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлыг судлан, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зарчмаар ажиллуулах талаар санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг Зам, тээврийн сайд, Төрийн өмчийн хорооны даргын 2013 оны 23/28 хамтарсан тушаалаар томилж, холбогдох судалгааг хийж, санал дүгнэлтээ гаргасан. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Зам, тээврийн сайдын зөвлөлийн 2013.05.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн, “Чингис хаан” ОУНБ-ыг 2014.01.01-ний өдрөөс аж ахуйн тооцоонд шилжүүлэн ажиллуулахаар тогтсон. Улмаар Зам, тээврийн сайд, Сангийн сайдын 2013 оны хамтарсан 32/93 дугаар тушаалаар “Чингис хаан” Олон улсын буудлын урсгал зардлыг өөрийн орлогоор санхүүжүүлж, 2014 оноос аж ахуйн тооцоонд шилжүүлэн ажиллуулахыг үүрэг болгосон. Үүний дагуу тус буудлын одоогийн байдлын танилцуулга, холбогдох мэдээллийг гаргасан. Үүнд:

- Хүний нөөцийн тооцоо судалгаа,
- Эдийн засгийн үзүүлэлт,
- Зорчигч тээвэрлэлтийн прогноз,
- Хөрөнгийн бүртгэл,
- Хөрөнгө оруулалтын хэмжээ,
- Санхүү, эдийн засгийн байдлын судалгааг хамруулав.

Иргэний нисэхийн ерөнхий газраас “Агаарын навигацийг хөгжүүлэх төсөл”, “Нисэх буудлыг хөгжүүлэх төсөл”-ийн зээлийн эргэн төлөлтийг 2014 онд дуусгах, шинэ нисэх буудал ашиглалтад орохтой холбоотойгоор “Чингис хаан” олон улсын буудлыг төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зарчмаар ажиллуулах асуудлыг хойшлуулсан. Манай улсын автозамын сүлжээ өргөжин тэлж, автозамын тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирснаар орон нутгийн нисэх зорчигчдын тоо буурч, нислэг багасч байгаа тул орон нутгийн нисэх буудлууд алдагдалтай ажиллаж байна. Иймд орон нутгийн нисэх буудлуудыг менежментийн гэрээгээр авч ажиллуулах санал санаачилга хувийн хэвшлээс гарахгүй байна.

Арга хэмжээ116.2: Алтай, Донойн нисэх буудлын ашиглалтыг сайжруулах, Хужирт, Эрдэнэт, Баруун-Урт, Арвайхээр, Өндөрхаан, Мандалговь хотын нисэх буудлын үйл ажиллагааг сэргээх ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ./2013-2016/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: *Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлсэн байна.*

Хэрэгжилт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Завхан аймаг дахь Нисэх буудлын хатуу хучилттай зурвасын барилгын ажил 70%-тай, 2013 онд 756.6 сая төгрөгийг санхүүжилт хийгдсэн бол Говь-Алтай аймгийн Нисэх буудлын хатуу хучилттай зурвасын барилгын ажил 86%-тай, 2013 онд 791.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Завхан чиглэлд 7 хоногт 2 удаа тогтмол нислэг гүйцэтгэж байна.

Булган аймгийн Залуугийн хөндийд байгуулах нисэх буудлын техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг боловсруулах ажлын даалгаврыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2015 онд батлуулж, ерөнхий захиалагч Монгол-

Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК-нд хүргүүлсэн бөгөөд санхүүжилтын асуудлыг тус компаний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар ажиллаж байна.

Сүхбаатар аймаг дахь Нисэх буудлын хөөрч буух шороон зурваст 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 84.5 сая төгрөгийн их засвар хийсэн. Алслагдсан бүс нутгийн ард иргэдэд агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын чиглэлд гүйцэтгэх татаастай нислэгийн зардлын тооцоо, судалгааг хийж, нислэг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан. Улаанбаатар- Баруун-Урт-Улаанбаатар чиглэлд “Тэнгэрийн улаач шинэ” ХХК шалгарч, 2013 оны 06 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулж, 22 удаа нислэг хийж, 335 зорчигч тээвэрлэсэн. ИНЕГ-аас агаарын тээвэрлэгч “Тэнгэрийн улаач шинэ” ХХК-д 121644000 сая төгрөгийн татаас олгосон.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын хөөрч буух шороон зурваст 2014 онд 50.0 сая, Дундговь аймаг дахь Нисэх буудлын хөөрч буух шороон зурваст 2013 онд 80.0 сая төгрөгийн их засвар тус тус хийсэн. Баруун -Урт, Өндөрхаан, Арвайхээр, Мандалговь нисэх буудлууд ИНД-139, ИНД-140 дүгээр дүрмүүдээр гэрчилгээжсэн бөгөөд ба багаас дунд оврын агаарын хөлөг хүлээн авах шаардлагыг бүрэн хангаад байна. Манай улсын автозамын сүлжээ өргөжин, автозамын тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан, агаарын хөлгийн шатахууны өндөр үнэ, валютын ханшны байнгын өсөлтөөс шалтгаалж агаарын тээврийн үйлчилгээний үнэ тариф буурахгүй, зорчигч урсгал байхгүй байгаа тул дээр чиглэл рүү нислэг үйлдэхэд агаарын тээврийн компаниуд их хэмжээний алдагдал хүлээхээр байгаа тул нислэг гүйцэтгэхгүй байна.

ЗОРИЛТ 117. “МИАТ” ТӨХК-д үндэсний агаарын тээвэрлэгчийн статус олгож, түүний 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгах

Арга хэмжээ 117.1.“МИАТ” ТӨХК-ийн удирдлага, менежментийг сайжруулах бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр хэрэгжүүлнэ./2013-2016 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт:Хөтөлбөр хэрэгжсэн байна.

Хэрэгжилт: Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 72 дугаар тогтоолоор “МИАТ” ТӨХК-д “Үндэсний агаарын тээвэрлэгч” статус олгосон. Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн удирдлага, менежментийг сайжруулах бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулахаар холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг Зам, тээврийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 80 дугаар тушаалаар томилж, хөтөлбөрийн төслийг боловсруулсан. “МИАТ” ХК-ийн бүтцийг шинэчлэх асуудлыг 2014.08.26-ны өдөр болсон компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, орон тоог 51-ээр бууруулахаар шийдвэрлэж, уг шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан. “МИАТ” ТӨХК-ийн санхүү, эдийн засгийн үр ашиг дээшлүүлэх, агаарын хөлгийн зээлийн төлбөрийн асуудал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд өндөр үнэтэй гадаадын менежментийн баг ажиллуулах боломжгүй байдлыг харгалзан Засгийн газрын 2015.02.09-ний өдрийн “МИАТ” ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 54 дүгээр тогтоолоор тус компанийн санхүүгийн үйл ажиллагааг хянах, мөнгөн хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх үүрэг бүхий менежментийн баг 12 сарын хугацаатай ажиллуулахаар шийдвэрлэсэн. “МИАТ” ТӨХК-д менежментийн баг ажиллуулах удирдамжийн төсөлд санал авах, уг менежментийн багт ажиллуулах ажилтан томилох санал Сангийн сайдаас ирүүлсний дагуу эхний шатанд санхүүгийн менежер ажиллуулахаар тогтож, томилон ажиллуулж байна. /2015.04.10-ны 01/1377 тоот/. УИХ-ын ЭЗБХ-оос “МИАТ” ТӨХК-д шалгалт хийх Ажлын хэсгийн мэргэжлийн дэд багт Зам, тээврийн яамнаас оролцон ажилласан. Менежментийн баг томилон ажиллуулах асуудал дээрх ажлын хэсгийн санал, ЭЗБХ-оос шийдвэр гарсны дараа хэлэлцэх санал, компанийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайлангийн хамт Сангийн яаманд хүргүүлсэн. /2015.06.09-ний 01/2506 тоот/ Бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр хэрэгжүүлэхээргүй болж холбогдох шийдвэрүүд гарсан бөгөөд тус яамнаас шалтгаалах ажил хийгдсэн. “МИАТ” ТӨХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг судалж, санал зөвлөмж гаргах ажлын хэсгийг Зам, тээврийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 287 дугаар тушаалаар байгуулж, МИАТ ТӨХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох талаархи Зам тээврийн сайдын 01 дүгээр

зөвлөмжийг хүргүүлсэн. “МИАТ” ТӨХК-ийн менежментийг концессоор хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлтээр оруулах асуудлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

Арга хэмжээ 117.2. “МИАТ” ХК-ийн 49 хүртэл хувийг дотоодын агаарын тээврийн компаниудад давуу эрхээр хувьчилна. /2013 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Хувьчлал явагдсан байна.

Хэрэгжилт: 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдөр өргөн баригдсан “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах” хуулийн төсөлд “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн Төрийн эзэмшлийн хувийг бууруулах буюу Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалтад “МИАТ” ТӨХК орсон бөгөөд компаний 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 49 хувийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахаар тусгасан байсан боловч УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах үндсэн чиглэл”, Засгийн газрын “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 2015 оны 330 дугаар тогтоолд тусгдаагүй, хасагдсан тул арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон.

ЗОРИЛТ 257: Европын Холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол Улсад нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх

Арга хэмжээ 257.1: Иргэний нисэхийн салбарт Европын холбооны нисэхийн аюулгүй ажиллагааны зарим стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ./2013-2016 он/

Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт: Стандартыг нэвтрүүлсэн байна.

Хэрэгжилт: Иргэний нисэхийн салбарт Европын холбооны нисэхийн аюулгүй ажиллагааны зарим стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэх ажлын хүрээнд 2013-2015 онд агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагуудыг болон инженер техникийн ажилтнуудыг гэрчилгээжүүлэхэд хэрэглэдэг иргэний нисэхийн багц дүрмүүдийг Европын Холбооны нисэхийн аюулгүй ажиллагааны стандартад шилжүүлэхээр төлөвлөсөн. Европын Холбооны /EASA/ дүрмүүдэд суурилагдсан ИНД-66 “Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл”, ИНД-145 “Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт”, ИНД-147 “Агаарын хөлгийн техник үйлчилгээний сургалтын байгууллага, гэрчилгээжүүлэлт” дүрмүүдийг боловсруулан, Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Дээрх шинэ дүрмийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчид, Европын Холбооны нисэхийн шинэ стандартад шилжихэд 2-3 жилийн бэлтгэл ажил шаардлагатай, мөн шинэ дүрмүүд нь үйл ажиллагааны бусад дүрмүүдтэйгээ зөрчилдөх тул эдгээр дүрмийг 2018 оноос эхлэн хэрэгжүүлэх /мөрдөж эхлэх/ хүсэлт гаргасан. Мөн 2015 оны 10 дугаар сард болсон Иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын гишүүн орнуудын Иргэний нисэхийн Захирлуудын 52 дугаар хурлын үеэр манай төлөөлөгчид Шинэ Зеландын Иргэний нисэхийн газрын удирдлагатай уулзаж, иргэний нисэхийн дүрмийн шинэчлэлтийн талаар санал солилцсон. Энэ уулзалтын үеэр Шинэ Зеланд улс нь EASA-ийн дүрмийн системд 2018 он гэхэд бүрэн шилжиж дуусахаар үе шаттайгаар ажиллаж байгаагаа мэдэгдсэн. Иймд дээрх нөхцөл байдалд үндэслэн 1999 оноос Шинэ Зеланд Улстай байгуулсан Хамтран ажиллах Санамж бичгийн дагуу Шинэ Зеландын дүрмүүд, Зөвлөмжийн цуврал, маягтууд болон бусад гарын авлага, заавар журмуудыг цаашид үргэлжлүүлэн авч хэрэглэх, улмаар 2018 он гэхэд Европын стандартад хэсэгчлэн биш, бүх ИНД-ийн хүрээнд цогц байдлаар шилжих зорилт тавьсантай холбоотойгоор ЗТЯ-д хүргүүлсэн 3 дүрмийг эргүүлэн татсан болно. Иргэний нисэхийн багц дүрмийн талаар авах арга хэмжээний тухай ИНЕГ-ын даргын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/791 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- 50 дүрэм /1949 хуудас/

- 162 Зөвлөмжийн цуврал /4455 хуудас/
- 242 маягт /984 хуудас/

англи хэлнээс орчуулах, боловсруулах, батлуулах ажил хийгдэж эхлээд байгаа бөгөөд 2016 оны эхний хагас жилд дуусгахаар төлөвлөж байна. Одоо хэрэгжүүлж байгаа ИНБД-ийн шинэчлэлийн төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрэх болно:

- Иргэний нисэхийн багц дүрэмд 2015 онд хийсэн хяналт-шинжилгээгээр илэрсэн зөрчлүүд /орчуулгын алдаа, дүрмийн зүйл, заалтыг үндэслэлгүйгээр өөрчилсөн, орхигдуулсан, хэрэглэгчдэд хүндрэл учруулсан зүйл, заалтыг дүрэмд үндэслэлгүйгээр нэмж тусгасан г.м/-ийг арилгаснаар дүрмүүд хэрэглэгчдэд ойлгомжтой, тодорхой болж, хяналтын үйл ажиллагааг хялбаршуулна.
- Иргэний нисэхийн үйл ажиллагаан дахь төрийн байгууллагын хүнд суртал, хууль, дүрмээс дээгүүр тавьсан шаардлага, дарамт шахалт багасах болно.
- Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих дүрмийн шаардлага тодорхой, энгийн, ойлгомжтой болох юм.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР